



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/05

Өлгий

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцинаар  
нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 08 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл, Дархлаажуулалтын зөвлөх хорооны 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад хамрагдах хүүхдийг тодорхойлох зааварчилгаа хүснэгтийг нэгдүгээр, улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакциныг хэрэглэх зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Нэгдүгээр хавсралтын дагуу 10 наснаас 15 насны хүүхдүүдийг улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцинаар 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн нэмэлтээр дархлаажуулахыг сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, эрхлэгч нарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан (Т.Ердаулет)-д тус тус үүрэг болгосугай.

3. Нэмэлт дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ажилтан (Т.Рахат), сум, тосгон, өрхийн дарга, эрхлэгч нарт нарт даалгасугай.

4. Дархлаажуулалтын үйл ажиллагаа, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтнүүдэд даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/188 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУВІРЖАН



**УЛААНБУРХАН, УЛААНУУД ӨВЧНИИ фСРЭГ НЭМЭЛТ  
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ ХҮҮХДИЙГ ТОДОРХОЙЛОХ  
ЗААВАРЧИЛГАА ХҮСНЭГТ**

ТОВЛОЛЫН ДАРХЛААЖУУЛАЛТ		НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТ	ГОЛОМТЫН ДАРХЛААЖУУЛАЛТ	НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ ЭСЭХ
УГУ I	УГУ II	2023 УУ	2025/2026 УУ	2026 УУ
+	+	+	-	Үгүй
+	+	-	-	<b>ТИЙМ</b>
+	-	-	-	<b>ТИЙМ</b>
-	-	-	-	<b>ТИЙМ</b>
+	+	-	+	Үгүй
+	-	-	+	<b>ТИЙМ</b> /Өмнөх тунгаас 28 хоногийн зайтай хийнэ/
-	+	-	+	<b>ТИЙМ</b> /Өмнөх тунгаас 28 хоногийн зайтай хийнэ/
-	-	+	+	<b>ТИЙМ</b> /Өмнөх тунгаас 28 хоногийн зайтай хийнэ/
-	-	-	+	<b>ТИЙМ</b> /Өмнөх тунгаас 28 хоногийн зайтай хийнэ/
Тодорхойгүй				<b>ТИЙМ</b>
2025-2026 оны дэгдэлтэд улаанбурханаар өвдсөн (Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, мэдээлэлд үндэслэн баталгаажуулна.)				Үгүй

УГУ- улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцин

УУ- улаанбурхан, улаануудын эсрэг вакцин

(+) - Вакцин хийлгэсэн.

(-) - Вакцин хийлгээгүй.

**ТИЙМ** - Вакцин хийнэ.

Үгүй - Вакцин хийхгүй.

## УЛААНБУРХАН, УЛААНУУД ӨВЧНИЙ ХАВСАРСАН ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Найрлага:

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг хавсарсан вакциныг (Эдмонстон Загреб) улаанбурхан, (Вистар РА 27/3) улаануудын амьд вирусээс гарган авсан.

Улаанбурхан, улаануудын вирусийг хүний диплоид эс дотор үржүүлсэн. Вакцин нь хөлдөөж хатаасан хуурай, тусгай уусгагч шингэнтэй, цайвар шаргал өнгө бүхий бодис юм. Вакцин нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын шаардлагыг TRS 840 (1994) аргачлалын дагуу хангасан.

### Хамгаалах чадвар:

0,5 мл буюу 1 хүн тун нь улаанбурханы вирусийг 1000 CCID50-иас цөөнгүй, улаануудын вирусийг 1000 CCID50 хэмжээгээр тус тус агуулсан.

### Хэрэглэх заавар:

Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг идэвхтэй дархлаа тогтоох зорилгоор нярай, хүүхэд, өсвөр насныхан, залуучуудад хэрэглэнэ. Вакциныг гуравт вакцин (сахуу, татран, хөхүүл ханиад), сахаруу татран, сүрьеэ, халдварт саа, хемофилюс инфюленза В хэв шинж, гепатит В вирус, шар чичрэгийн эсрэг вакцин, А аминдэмтэй цуг хэрэглэж болно.

Товлолт болон нөхөн дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс үл хамааран нэмэлт дархлаажуулалтад хамруулах бөгөөд хэрэв хүүхэд сүүлийн 1 сарын дотор аль нэг вакцин, иммуноглобулинд хамрагдсан бол улаанбурхан, улаануудын эсрэг вакцин хийхийг түр хойшлуулан сарын дараа нэмэлт дархлаажуулалтад хамруулах.

### Тун хэмжээ:

Вакциныг тарихдаа нэг удаагийн ариун зүү, тариур хэрэглэх бөгөөд зөвхөн вакциныг дагалдаж ирсэн уусгагчаар найруулна. Уусгагчийг хийж зөөлөн сэгсрэхэд нунтаг бодис хялбар уусна. Вакциныг найруулсан даруйдаа 0,5 мл-ээр соруулан авч, бугалгын дээд хэсгийн арьсан дор тарина. Вакциныг найруулснаас хойш 6 цагийн дотор +2-+8 хэмд хадгалж хэрэглэнэ. 6 цагийн дараа задалсан вакциныг устгана.

Вакциныг өөр үйлдвэрлэгчийн улаанбурхан, улаануудын эсрэг вакцины найруулах уусмал болон тарилгын шингэнээр найруулж болохгүй. Өөр уусгагчаар найруулснаас вакцины чанарт нөлөөлөх, хүнд урвал илэрч болзошгүй. Уусгагч шингэнийг хөлдөөж болохгүй. Уусгагч шингэн болон найруулсан вакцинд гаднын биет хөвсөн, бохирдсон байвал устгана.

### Хариу урвал:

Дархлаажуулалтын дараах урвалууд хөнгөн явагддаг. Вакцин хийлгэсний

дараа 24 цагийн дотор тарьсан газар улайх, бага зэрэг эмзэглэлтэй байж болно.

Дээрх шинж тэмдгүүд ихэвчлэн 2-3 хоногийн дараа ямар нэг эмчилгээгүй арилна.

Вакцин хийлгэсэн хүмүүсийн 5-15%-д нь 7-12 хоногийн дараа хөнгөн халууралт ажиглагдаж 1-2 өдрийн дараа арилна. Вакцин хийлгэснээс 7-10 хоногийн дараа ойролцоогоор 2%-д хөнгөн тууралт ажиглагдаж, 2 хоног үргэлжилнэ. Улаанбурханы эсрэг вакцины 1 сая хүн тун тутамд 1 энцефалит бүртгэгдэх боломжтой боловч вакцинтай хамааралтай болох нь батлагдаагүй. Бага зэргийн халууралт, тууралт, лимфаденопати, булчингийн өвдөлт, парастесиа ихэвчлэн бүртгэгддэг. Тромбоцитопения ховор тохиолдох бөгөөд 30,000 тун тарихад нэгээс бага тохиолдол бүртгэгдсэн байна. Анафилактик шок ховор тохиолдолд бүртгэгдэнэ.

Вакцин хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор иммуноглобулиныг хийлгэж болохгүй. Иммуноглобулин, цус ийлдэс хийсний дараа зургаан долоо хоногийн хугацаанд улаанбурхан улаануудын эсрэг вакциныг хийхгүй, боломжтой бол 3 сарын дараа вакцинд хамрагдахыг зөвлөнө.

***Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдад дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлтэй холбоотой зөвлөмж мэдээллийг заавал өгнө.***

#### **ЭСРЭГ ЗААЛТ, АНХААРУУЛГА:**

Уг вакциныг дараах тохиолдолд хэрэглэхгүй. Үүнд:

- Кортикостеройд, бусад төрлийн дарангуйлах эм, туяа эмчилгээ, стеройдын өндөр тунгаар эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд,
- Халуурсан, цочмог халдварт өвчин, жирэмсэн, лейкеми, лимфома, хурц цус багадалт, цусны тогтолцооны бусад цочмог өвчин, бөөрний үйл ажиллагааны хурц дутагдлын үед,
- Декомпенсацийн шатанд буй зүрхний өвчний үед,
- Иммуноглобулин хийлгэсэн эвсэл цус сэлбүүлсэн тохиолдолд,
- Вакцины найрлагад орсон бодист харшилтай,
- Неомицинд өмнө нь анафилакси эсвэл хүнд хэлбэрийн харшлын урвал өгч байсан,
- Жирэмсэн үед,
- Үхрийн сүүнд харшилж байсан өгүүлэмжтэй.

Харин бага зэргийн халуунтай, хөнгөн хэлбэрийн амьсгалын замын халдвартай болон суулгалттай, хоол тэжээлийн дутагдалтай хүүхдүүд эсрэг заалтад орохгүй.

Энэ тохиолдолд эмчийн үзлэгээр вакциныг хойшлуулах эсэхийг шийдвэрлэнэ.

#### **Хадгалах нөхцөл, хугацаа:**

Вакциныг гэрлээс хамгаалж +2-+8 хэмд харанхуй газар хадгална.

Уусгагч шингэнийг хөлдөөж болохгүй, сэрүүн нөхцөлд хадгална.

Вакцин шошгоны заагуур болон вакцины флакон дээрх дуусах хугацааг харж хэрэглэнэ.

Вакциныг үйлдвэрлэсэн: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын "Серум Институт" вакцины үйлдвэр.